В. Нэгэн төрлийн уусмал болгох зорилгоор

С. Ингредиентүүдийн харилцан үйлчлэлцлээс сэргийлэх

Д. Уусгагчийн алдагдлыг багасгах

Е. Бодисуудыг сайн уусгах зорилоор

/171./ Цардуулын цавуу бэлтгэхэд цардуулыг ямар байдлаар халуун усанд оруулах вэ?

А. Хуурай байдлаар

В. Суспенз байдлаар

С. Эмульс байдлаар

Д. Комплекс байдлаар

Е. Тосон уусмалаар

/172./ Гадуур ба дотуур хэрэглэх шингэн эмийн хэлбэрийг жин, жин-эзлэхүүний аргаар бэлтгэж эзлэхүүнээр олгоно. Яагаад гэвэл 5% ба түүнээс дээш эмийн бодис орсон цийдмэгийг аагтай цийдмэг гэнэ.

/173./ Жигд ширхэгтэй нэгэн төрлийн нунтаг бэлтгэхэд бэлтгэхийн тулд нэг шигшүүрээр шигшиж том хэсгүүдээс салгаад түүнийг дараагийн номерын шигшүүрээр шигшиж жижиг хэсгээс нь салгана. Яагаад гэвэл ганц шигшүүрээр шигшихэд жигд ширхэгтэй нунтаг болдоггүй.

/174./ Тарилгын эмийн хэлбэрийг найруулахад нэрмэл усыг хэрэглэдэг. Яагаад гэвэл нэрмэл усанд бага ч гэсэн бичил биетэн орсон байвал тэр нь халууруулах, судас бөглөх мэт хүнийг үхэлд хүргэж болох аюултай.

/175./ Фармакопей гэдэг нь эмийн зүйлүүд, эмийн хэлбэрүүдийн чанарын хэм хэмжээг тогтоосон стандарт заавруудын эмхэтгэл юм. Ийм учраас фармакопейд ямар ч мадаггүй болтлоо шалгагдсан зүйлүүдийг түүвэрлэн бичих бөгөөд сурах бичиг биш харин хуулийн хүчинтэй гарын авлага юм.

/176./ Нийлмэл нунтаг бэлтгэх технологийг уур нүдүүрийг сонгож авахаас эхэлнэ. Яагаад гэвэл нунтагийн бүх жин нь уурын тохиромжтой ачаалалд ойрхон байх бөгөөд дээд ачааллаас хэтрэхгүй байх ёстой.

/177./ Ургамалын түүхий эдээс усан ялгамал бэлтгэх нь экстракт-концентраатаас бэлтгэснээс илүү сайн чанартай байдаг. Яагаад гэвэл үйлчлэгч бодис нь гүйцэд ялгардаг.

/178./ Хортой, дэгдэмхий, хурц үнэртэй эмийн бодис оролцсон нунтагийг найруулахдаа таглаатай уур, шигшүүр хэрэглэж амны хаалт зүүвэл зохино. Яагаад гэвэл ам, хамар, нүдэнд орж салст бүрхэвчийг цочроохгүй.

/179./ Шингэн эмийн найрлаган дах хуурай эмийн бодисын хэмжээ нь 4% хүртэл байвал жоронд бичсэн хэмжээгээр авч, хэмжиж авсан уусгагчид нь уусгадаг. Яагаад гэвэл сахарын шүүс, янз бүрийн концентрацтай этанол, шингэн бэлдмэлүүдийг эзэлхүүнээр хэмжиж авна.

/180./ Шилэн шүүлтүүрээр шүүхэд уусмалын эзэлхүүн нь хорогддоггүй сайн талтай. Ийм учраас алкалоид, будагч бодис, ферментийн уусмалыг шүүхэд хэрэглэж болохгүй.

/181./ Жинтэй ажиллахдаа туухай ба жигнэх зүйлийг тавгийн голд тавина. Яагаад гэвэл жингийн зүүн тавган дээр туухайг, баруун тавган дээр эмийн бодисыг жигнэнэ.

/182./ Дулааны аргаар ариутгах үед ариутгалын чанарыг сайжруулахын тулд сайн цэвэрлэсэн байх шаардлагтай. Яагаад гэвэл тоос, шороо, цус бусад органик шингэнээр бүрхэгдсэн бичил биетэн өндөр температурын нөлөөнөөс нэлээд хугацаагаар хамгаалагдсан байдаг.

/183./ Уусгагчийг сонгон авахдаа “төстэй зүйл төстөйдөө” уусна гэсэн дүрмийг баримтална. Иймээс ямар нэгэн бодисыг уусгахад түүнтэй бүтцээрээ ойролцоо уусгагчийг авна.

/184./ Ариутгал гэдэг нь микроорганизмуудыг бүрэн устгах процесс юм. Яагаад гэвэл ариутгалын горим нь микрофлорын төрөл ба эмийн бодисын физик, химийн чанараас хамаарах учир тарилгын эм тус бүрт ариутгалын дэглэмийг зааж өгөх шаардлагатай.

/185./ Тарилгын уусмалыг бэлтгэхэд хэрэглэгддэг эмийн бодисууд нь чанарын хувьд фармакопейн шаардлага хангасан химийн цэвэр ба шинжилгээнд зориулсан цэвэр зэрэглэлийн бодисууд байх ёстой. Яагаад гэвэл эмийн бодис нь заавал ямар нэгэн хольцыг өөртөө агуулсан байдаг.

/186./ Усан ялгамал нь бичил биетэн үржих тохиромжтой орчин учир амархан мууддаг. Яагаад гэвэл усан ялгамалыг бэлтгэж буй технологи нь түүнийг ариун чанартай болгож чаддаггүй.

/187./ Цийдмэгийн дисперсийн фазын жижиг хэсгийн хэмжээ хэд вэ?

- A. 1 нм
- B. 1-100 нм
- C. 0,1 -5 мкм
- D. 1-150 мкм
- E. 150-300 мкм

/188./ Хайлш хэлбэрийн тосон түрхэц бэлтгэхдээ ямар бодисоос эхлэж хайлуулдаг вэ?

- A. Эмийн бодис
- B. Суурь бодисыг
- C. Өндөр температурт хайлдаг суурь бодисыг
- D. Амархан уусдаг бодис
- E. Уусдаггүй бодисыг

/189./ Хортой эмийн бодисын тритурац бэлтгэхэд туслах бодисоор ямар бодис авдаг вэ?

- A. Глюкоз
- B. Лактоз
- C. Сахароз
- D. Рамноз
- E. Фруктоз

/190./ Цацлага бэлтгэхэд ямар онцлог байдаг вэ?

- A. Тугналт нь нарийн зөв байх ёстой.
- B. Маш нарийн торгон нунтаг болтол нь жижиглэх ёстой
- C. Тритураци ашиглана
- D. Тун хэмжээг нарийн шалгана.
- E. Жигд ширхэгтэй болтол жижиглэнэ.

/191./ Шинэ галены бэлдмэлүүдийн бусад галены бэлдмэлүүдээс ялгагдах онцлогийг нэрлэ.

1. Биологийн аргаар стандартчилагддаг.
2. Бэлдмэлүүдийг цэвэршүүлэхийн тулд олон төрлийн уусгагчид ашигладаг

3. Дагалдах бодисуудаас бараг бүрэн цэвэрлэгдсэн, гол үйлчлэгч бодис бараг дангаараа ялгагдсан.

4. Цэвэрлэгээ муу хийгдсэн байдаг.

5. Тухайн ургамлын өнгө, үнэр, амтыг хадгалаагүй байдаг.

/192./ Хандмалыг хэрхэн ангилах вэ?

1. Өтгөн

2. Энгийн

3. Тосон

4. Нийлмэл

5. Эктракт концентрац

/193./ Өтгөн ханд бэлтгэх технологийн схемд аль нь хамаарагдах вэ?

1. Ялгамалыг цэвэрлэх

2. Стандартчилах

3. Өтгөрүүлэх буюу өтгөн ханд гаргаж авах

4. Ялгамал гаргаж

5. Савлах

/194./ Цэцгийн тос гарган авах аргыг заана уу?

1. Шахах арга

2. Усны ууртай нэрэх арга

3. Хандлах арга

4. Анфлеражийн арга

5. Динамик адсорбцын арга

/195./ Ферментийн гаралтай бэлдмэлийг ямар аргаар ариутгах нь хамгийн зохимжтой вэ?

1. Дулааны

2. Химийн

3. Өндөр даралтан дор ариутгах

4. Мембранан шүүлтүүрээр шүүх

5. Механик арга

/196./ Май цэцгийн хандмалд агуулагдах бодисыг заана уу?

1. Сапонин

2. Эфирийн тос

3. Флавноид

4. Зүрхний гликозид

5. Алкалоид

/197./ Чихэр өвсний өтгөн ханд 100 кг-ыг бэлтгэхэд 25% хандлагдах бодис агуулсан түүхий эд хичнээнийг авах вэ?

1. 280 кг

2. 200 кг

3. 100 кг

4. 300 кг

5. 50 кг

/198./ Шүүлтийн процессыг идэвхжүүлэх аргуудыг сонго.

1. Шүүгдэж буй шингэний дээрээс даралтаар үйлчлэх

2. Шүүгдэж буй шингэний баганы өндрийг нэмэгдүүлэх

3. Шүүгдэж буй шингэний дороос шүүлтэнд агаарын сийрэгжилт үүсгэх

4. Шүүлтийн материалыг нимгэн болгох

5. Шүүгдэж буй шингэний зуурамтгай чанарыг нь багасгах

/199./ Хуурай ханд бэлтгэх технологийн процессийг нэрлэнэ үү?

1. Хандлах

2. Цэвэрлэх, өтгөрүүлэх

3. Хатаах

4. Стандартчилах

5. Эмийн хэлбэрт оруулах

/200./ Реперколяцийн аргад түүхий эдийг тэнцүү хэмжээгээр хувааж хийдэг ямар аргууд байдаг вэ?

1. АНУ-ын ФК-н арга
2. Босины арга
3. Германы ФК-н арга
4. Чулковын арга
5. Циркуляцийн арга

/201./ Хатаасан ургамлын түүхий эд нь шинэ түүсэн ургамлын түүхий эдийг бодвол биоидэвхт бодисын найрлага ба агууламж нь өөр байдаг. Үүний шалтгаан нь юу вэ?

1. Уурших, дэгдэх, агаарын хүчилтөрөгч, гаднын бусад нөлөөгөөр чанар, тооны өөрчлөлтөнд орсон байдаг.
2. Эсийн ханын хагас нэвтрүүлэх шинж алдагдсан байдаг тул хандлагдахдаа сайн болдог.
3. Ферментийн нөлөөгөөр задралд орсон байдаг.
4. Үйлчлэгч бодис нь гидролизд орсон байдаг.
5. Дагалдах бодисууд хандлах процесст муугаар нөлөөлдөг.

/202./ Түүхий эдээс болон эмийн бодис нэмж идээшмэл, чанамал бэтгэх технологт аль нь хамаарагдах вэ?

1. Түүхий эдийг жижиглэх
2. Хандлах
3. Эмийн бодисоо оруулах
4. Өтгөрүүлэх
5. Ялгах

/203./ Панкипсинийг амьтны ямар эрхтэнээс гаргах вэ?

1. Өндгөвч
2. Ходоодны салст бүрхэвч
3. Төмсөг
4. Нойр булчирхай
5. Элэг

/204./ Ферментийн гаралтай бэлдмэлийг ариутгахад ашиглах шүүлтүүрийн нүхний диаметрийн хэмжээ хэд байж болох вэ?

1. 0,1-0,2 мкм
2. 0,1-0,3 мкм
3. 0,2-0,3 мкм
4. 0,2-0,4 мкм
5. 0,1-0,4 мкм

/205./ Хандмалыг хадгалах нөхцөлүүдийг нэрлэнэ үү?

1. Гэрлээс хамгаалах
2. Ууршилтаас хамгаалах
3. Температурын нөлөөнөөс хамгаалах
4. Чийгнээс хамгаалах
5. Задралтаас хамгаалах

/206./ Фитонцид агуулсан ургамлын түүхий эдийг сонгоно уу.

1. Бамбайн ханд
2. Сонгино
3. Алтан гагнуур
4. Таана
5. Бамбай

/207./ Үйлчлэгч бодисын дээд хязгаарыг тогтоосон хуурай хандыг заана уу?

1. Гишүүний хуурай ханд
2. Гуа хатны хуурай ханд
3. Чихэр өвсний хуурай ханд
4. Алтан хундаганы хуурай ханд
5. Тарваган шийрийн хуурай ханд

/208./ Хуурай ханд гаргаж авах технологийн схемд аль нь хамаарагдах вэ?

1. Хатаах ба хуурай ханд гаргаж авах
2. Стандартчилах
3. Ялгамалыг цэвэрлэх

4. Савлаж хадгалах
 5. Ялгамал гаргаж авах
- /209./ Этилийн спирт амьтны гаралтай ямар түүхий эдийг даршлахад илүү тохиромжтой вэ?
1. Өнчин тархи
 2. Төмсөг
 3. Бамбай булчирхай
 4. Өндгөвч
 5. Элэг
- /210./ Түүхий эдийг хэт жижиглэхэд ямар муу талууд илрэх вэ?
1. Хандлагч шингэний нэвтрэн орох процесс муудна
 2. Гарган авсан ялгамал булингартана
 3. Хандлах процесс удааширна
 4. Түүхий эдийн экстрагенттэй хүрэлцэх талбай ихэснэ
 5. Түүхий эдийн технологийн шинж чанар сайжирна
- /211./ Хандлах үед явагдах процессуудыг нэрлэ.
1. Диффузи
 2. Диализ
 3. Десорбци
 4. Уусах процесс
 5. Хандлагдах процесс
- /212./ Шингэн хандыг гаргаж авах технологийн схемд аль нь хамаарагдах вэ?
1. Хандлах
 2. Ялгамалыг цэвэрлэх
 3. Савлах
 4. Түүхий эдийг бэлтгэх
 5. Экстрагентыг бэлтгэх
- /213./ Шинэ галены бэлдмэл гарган авахад ямар шинж чанартай хандлагчдыг хэрэглэдэг вэ?
1. Ямар нэгэн хүчтэй химийн нөлөө бага зэрэг
 2. Ялган авахын тулд өндөр t_0 шаарддаггүй
 3. Заавал устай холилддог шинж чанартай.
 4. Ялган авах бодисыг сонгомлоор уусгадаг.
 5. Химийн хувьд нэг төрлийн
- /214./ Хатааж тосгүйжүүлэн жижиглэсэн эд, эрхтэний бэлдмэлийн технологийн процессийг нэрлэнэ үү?
1. Түүхий эдийг хатаах
 2. Тосгүйжүүлэх
 3. Жижиглэх
 4. Эмийн хэлбэрт оруулах
 5. Хандлах
- /215./ 1:2 харьцаатай бэлтгэдэг түүхий эдийг нэрлэнэ үү?
1. Шар модны хандмал
 2. Алтан хундаганы шингэн концентрат
 3. Ганганы шингэн ханд
 4. Чихэр өвсний шингэн ханд
 5. Хотойн хандмал
- /216./ Молекул диффузид нөлөөлөх хүчин зүйлүүдийг нэрлэнэ үү?
1. Халаалт
 2. Уусгагчийн зуурамтгай чанар
 3. Түүхий эдийн жижиглэлт
 4. Хандлах хугацаа
 5. Молкулын кинетик энерги
- /217./ Хуурай хандны чанарыг ямар шалгуураар шалгадаг вэ?
1. Чийглэг
 2. Хүнд металлын хэмжээ
 3. Үйлчлэгч бодисын хэмжээ

4. Ялгамалын нягт
5. Ялгамалын савлагаа

/218./ Шинэ галены бэлдмэл гарган авахад өөр өөр хандлагчдыг дараалан хэрэглэх нь ямар зорилго агуулдаг вэ?

1. Химийн хувьд нэгэн төрлийн цэвэр бодис ялган авах
2. Дагалдах бодисыг аль болох уусгахгүй байх
3. Өөр өөр хандлагчид уусдаг бодисуудыг дараалуулан ялгах
4. Тогтвортой, тунадас үүсгэдэггүй бэлдмэл ялган авах
5. Муутгахаас хамгаалан цэвэрлэгээ хийдэг.

/219./ Хуурай ханданд агуулагдах чийглэгийн хэмжээ ямар байх ёстой вэ?

1. 1%-иас багагүй
2. 3%-иас багагүй
3. 10%-иас багагүй
4. 5%-иас багагүй
5. 25%-иас багагүй

/220./ Хандлах процесст нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү?

1. Түүхий эдийн технологийн шинж чанар
2. Температурын нөлөө
3. Хандлах хугацаа
4. Хандлагч шингэний шинж чанар
5. Хандлагч шингэнийг сонгон авах

/221./ Хандмалуудыг мэдрэхүйн эрхтэний тусламжтайгаар шалгаж үзэхэд ямар шаардлага хангаж байх ёстой вэ?

1. Ургамлын түүхий эдэд агуулагдаж байгаа бодисын үнэр, амтыг хадгалсан байх
2. Нэг төрлийн байдал
3. Тунгалаг байх
4. Спиртийн амттай байх
5. Гашуун амттай байх

/222./ Диффузлэгдэх бодисын хэмжээтэй шууд хамааралтай үзүүлэлтийг заана уу?

1. Фазын зааглагч гадаргуу
2. Диффузийн коэффициент
3. Концентрацын ялгаа
4. Диффузи явагдах хугацаа
5. Диффузи явагдах үеийн зузаан

/223./ Нэрмэл усаар халаалт хэрэглэж хандлалт явуулахад илрэх дараах хүчин зүйлүүдээс аль нь хандлалтад муугаар нөлөөлөх вэ?

1. Уураг ихээр ялгарах
2. Цардуул хөвмөл үүсгэнэ
3. Салс ялгарна
4. Шингэний хөдөлгөөн идэвхжинэ
5. Коньюктив диффузи нэмэгдэнэ

/224./ Үйлчлэгч бодисын дээд хязгааргыг тогтоогоогүй хуурай хандыг заана уу?

1. Гишүүний хуурай ханд
2. Тарваган шийрийн хуурай ханд
3. Чихэр өвсний хуурай ханд
4. Алтан хундагны хуурай ханд
5. Гуа хатны хуурай ханд

/225./ 54. Шингэн хандыг перколяцийн аргаар гарган авахад эхний ялгамалыг ямар хэмжээтэйгээр авах вэ?

1. 75%
2. 100%
3. 50%
4. 85%
5. 90%

/226./ Хандыг балластик бодисуудаас цэвэрлэх аргуудыг тоочно уу?

1. Халаах
2. Спиртээр тунадасжуулах
3. Мембранан шүүлт хэрэглэх
4. Адсорбент нэмэх
5. Диалезийн аппарат ашиглах

/227./ Шинэхэн ургамалаас өтгөрүүлээгүй шүүс гарган авахад түргэн халааж, түргэн хөргөх нь чухал байдаг. Энэ нь шүүсний чанарт нөлөөлөх бөгөөд зорилготой.

1. Үйлчлэгч бодисыг сайн ялган авахад
2. Уураг, пектиний бодисыг тунадасжуулах
3. Тунгаах, тунадасжуулах
4. Тунгалагжуулах
5. Муутгахаас урьдчилан сэргийлэх

/228./ Биомассыг хатаасны дараа үлдэгдэл чийглэг хэдэн хувиас ихгүй байх ёстой вэ?

1. 5%
2. 25%
3. 20%
4. 12%
5. 10%

/229./ Тосон хандны үйлдвэрлэлд ашиглаж болох хандлагчийг заана уу?

1. Ургамалын тос
2. Метилен хлорид
3. Этанол
4. Минералын тос
5. Органик уусгагч

/230./ Өтгөн хандыг цэвэрлэхэд ямар аргыг хэрэглэдэг вэ?

1. Буцалгаж цэвэрлэх арга
2. Спиртээр тунадасжуулах арга
3. Адсорбцын арга
4. Диализ
5. Электродиализ

/231./ Ямар ч түүхий эдийг хандлахын өмнө заавал дэвтээх шаардлагатай. Учир нь дэвтээхэд түүхий эд хөөж, хадлагч шингэн орох боломж сайжирна.

/232./ Этилийн спиртийн эзлэхүүний процентыг 200С-д хэмжинэ. Учир нь спиртийн эзэлхүүн температураас хамааран өөрчлөгддөг.

/233./ Хандлалтын үед концентрацын ялгааг ихэсгэхийн тулд хандалгчийг үе үе солино. Учир нь концентрацын ялгаа их байх нь хандлах процессыг нэмэгдүүлэнэ.

/234./ Хандлах процессыг эрчимжүүлэхийн тулд гадаргуугийн идэвхт бодис нэмж болно. Учир нь гадаргуугийн идэвхт бодис фазуудын гадаргуугийн таталцлын хүчийг нэмэгдүүлнэ.

/235./ Ургамалын түүхий эдийг хандлахын өмнө жижиглэх шаардлагатай. Учир нь гадаргуугийн талбай ихэссэнээр хандлагчтай хүрэлцэх талбай нэмэгдэнэ.

/236./ Мацерацын аргыг хуйлруулж хандлах замаар эрчимжүүлж болно. Учир нь квитацын үзэгдэл хандлалтыг түргэснэ.

/237./ Тарилгын зориулалтаар хэрэглэх фермент ба дааврын гаралтай бэлдмэлийг мембранан шүүлтүүрээр шүүх аргаар ариутгана. Учир нь ихэнх фермент даавар нь тогтвор муутай байдаг.

/238./ Дэвтээсэн түүхий эдийг перколяторт хийхдээ чигжилтийг тохируулах нь чухал. Учир нь чигжилт сийрэг байвал экстрагент түүхий эдэд нэвтрэн ороход сайнаар нөлөөлнө.

- /239./ Түүхий эдийг хэт жижиглэх нь хандлалтад сайнаар нөлөөлнө. Учир нь хэт жижиглэхэд хандлагч шингэний түүхий эдэд нэвчин орох чадвар нэмэгдэнэ.
- /240./ Цахилгаан гүйдлийн нөлөөгөөр дотоодын диффузийн процесс ихэснэ. Учир нь биологийн идэвхт бодисын молекулын ионы хөдөлгөөн хурдасна.
- /241./ Нунтагийн урсах чанар гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?
- A. Нунтаг эмийн бодисын урсах чанарыг хэлнэ
 - B. Нунтаг бодисын гоожих чадварыг хэлнэ
 - C. Нунтаг бодисын янз бүрийн бодистой хамт урсах чадварыг хэлнэ
 - D. Нунтаг эмийн бодис нь өөрийнхөө хүндийн жингээр гоожих чадварыг хэлнэ
 - E. Тодорхой эзлэхүүнтэй нунтагийн урсах чадварыг хэлнэ
- /242./ Нянгийн эсийн уураг задарч, эргэлтгүй коагуляцид орж ферментийн систем нь гэмтэж үхдэг ариутгах аргыг нэрлэнэ үү?
- A. Халууны арга
 - B. Шүүж ариутгах арга
 - C. Хэт ягаан туяагаар ариутгах арга
 - D. Радиацийн арга
 - E. Физикийн арга
- /243./ Тун шилний дотор талыг ямар аргаар угаах вэ?
- A. Химийн
 - B. Физикийн
 - C. Тариурын
 - D. Конденсацын
 - E. Биологийн
- /244./ Агаарын хэвтээ ламинар урсгалын хурд хэд вэ?
- A. 0,36 м/сек
 - B. 0,65 м/сек
 - C. 0,25 м/сек
 - D. 0,45 м/сек
 - E. 0,15 м/сек
- /245./ Дозаторыг ажиллагаанд хэрэглэхийн өмнө ямар уусмалаар арчиж ариутгах вэ?
- A. Спирт эфирийн холимогоор
 - B. Буцалсан усаар
 - C. Эфирээр
 - D. Формалинээр
 - E. Этанолоор
- /246./ Дамжин бохирдох гэж юу вэ?
- A. Нэг бүтээгдэхүүний эхлэл материал, дамжлагын бүтээгдэхүүн эсвэл бэлэн бүтээгдэхүүн нь өөр бүтээгдэхүүний эхлэл материал болон үйлдвэрлэлийн явцын материалаар бохирдохыг хэлнэ
 - B. Үйлдвэрлэлийн явцад завсрын ба эцсийн бүтээгдэхүүн нь өөр бусад эхний материал ба эцсийн бүтээгдэхүүнээр бохирдохыг хэлнэ
 - C. Эцсийн савлалт, хаяглалтыг оруулан үйлдвэрлэлийн бүх шатны бохирдолтыг хэлнэ
 - D. Эмийн бүтээгдэхүүний чанарын өөрчлөлтийн шалтгаан нь болдог процесс
 - E. Эхний материал, эцсийн савлалт, хаяглалт зэрэг нь үйлдвэрлэлийн бүх бүтээгдэхүүнийг бохирдуулахыг хэлнэ
- /247./ Тусгайлсан заалт байхгүй бол бүрхүүлгүй шахмал ямар хугацаанд задрах вэ?
- A. 30 мин –аас ихгүй
 - B. 10 мин –аас ихгүй
 - C. 15 мин –аас ихгүй
 - D. 5 мин –аас ихгүй
 - E. 3 мин –аас ихгүй
- /248./ Мөнгөн усны шар ислийн хэдэн %-ийн тосон түрхэцийг нүдний практикт хэрэглэх вэ?

- A. 3%
- B. 2%
- C. 1%
- D. 1,5%
- E. 2,5%

/249./ Үйлдвэрлэл ба чанарын хяналт хариуцсан менежер нь мэргэжлээрээ хэдээс доошгүй жил ажилласан байх ёстой вэ?

- A. 2
- B. 1
- C. 3
- D. 6
- E. 5

/250./ Шулуун гэдэсний капсулын бүрхүүлийг бэлтгэхдээ дараах бодисуудыг ямар харьцаагаар бэлтгэх вэ?

- A. Желатин 20%, глицерин 10%
- B. Желатин 1 хэсэг, глицерин 3 хэсэг, ус 5 хэсэг
- C. Желатин 3 хэсэг, глицерин 1 хэсэг, ус 5 хэсэг
- D. Желатин 70%, глицерин 30%
- E. Желатин 1 хэсэг, глицерин 5 хэсэг, ус 4 хэсэг

/251./ Линимент гэж юу вэ?

A. Тасалгааны температурт өөрийнхөө хэлбэрийг хадгалж чаддаг, биеийн температурт хайлдаг тосон эмийн хэлбэр

B. Арьс салст бүрхэвчинд түрхэж хэрэглэдэг, унжралдсан өтгөвтөр консистенцтэй, гадуур хэрэглэдэг, нийлмэл тосон эмийн хэлбэр юм

C. Харилцан уусдаггүй нарийн жижиглэгдсэн шингэнүүдээс тогтох бөгөөд гадаад байдлаараа нэгэн төрлийн гадуур, дотуур болон тарилгаар хэрэглэдэг тосон эмийн хэлбэр

D. Арьс салст бүрхэвчинд түрхэж хэрэглэдэг, унжралдсан өтгөвтөр байдалтай дотуур хэрэглэдэг эмийн хэлбэр

E. Арьс салст бүрхэвчинд шингээн түрхдэг, унжралдсан өтгөвтөр байдалтай, дотуур хэрэглэдэг, тунлагдсан тосон эмийн хэлбэр

/252./ Үйлдвэрийн ердийн гэрэлтүүлэг хэд вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 450 люкс
- B. 350 люкс
- C. 300 люкс
- D. 265 люкс
- E. 500 люкс

/253./ Туншилтэй тарилгинуусмалын өнгийг ямар аргаар шалгах вэ?

- A. Микроскопоор шалгаж
- B. Метилен хөхийн уусмалд хийж
- C. Эталон уусмалтай харьцуулж
- D. Нэрмэл устай харьцуулж
- E. Рентген туяаны тусламжтайгаар

/254./ 1-р зэрэглэлийн цэвэршилттэй өрөөнд дараах үйлдлүүдийн алийг нь хийх вэ?

- A. Туслах материалыг угааж ариутгах
- B. Уусмалыг савлах
- C. Туншил үйлдвэрлэх
- D. Уусмал найруулах
- E. Уусмал ариутгах

/255./ Шахмал эмийн үйлдвэрлэлд хэрэглэгддэг туслах бодисын нийт хэмжээ ямар байх ёстой вэ?

- A. 5%-иас ихгүй
- B. 7%-иас ихгүй
- C. 10%-иас ихгүй
- D. 20%-иас ихгүй

- Е. 25%-иас ихгүй
- /256./ Тун шилтэй тарилгын уусмалын дүүргэлтийг ямар аргаар шалгах вэ?
- А. Вакуумын аргаар
 - В. Хар цагаан дэлгэцэн дээр үзэх
 - С. Шприцийн аргаар
 - Д. Ижил хэмжээний уусмалтай харьцуулж
 - Е. Микроскопоор
- /257./ Уусмал бэлтгэхэд зориулагдсан шахмалын задрах хугацааг сонгоно уу?
- А. 30 мин-аас ихгүй
 - В. 15 мин-аас ихгүй
 - С. 60 мин-аас ихгүй
 - Д. 5 мин-аас ихгүй
 - Е. 10 мин-аас ихгүй
- /258./ Сахарын сироп бэлтгэдэг дээд зэргийн цэвэршилттэй рафинад сахарын агууламж хэдэн хувь байдаг вэ?
- А. 25%
 - В. 99,9%
 - С. 90%
 - Д. 50%
 - Е. 75%
- /259./ Хуурай халуун аргаар ариутгах процесс юунд үндэслэдэг вэ?
- А. Ариутгах камерт хуурай халуун агаар эргэлдэж байхад үндэслэгдэх ба гаднаас агаар орохоос сэргийлэхийн тулд нэмэлт даралтыг камерт барьж байх ёстой
 - В. Ариутгалд камераас агаарыг гадагшлуулахад үндэслэгддэг
 - С. Ариутгалд хэрэглэгдэж буй уур нь өндөр даралттай байх ёстой
 - Д. Ариутгах камерт халуун уур оруулахад үндэслэгддэг
 - Е. Ариутгах камерт халуун агаар оруулах хэрэгтэй
- /260./ Усан уусмалыг микробоор бохирдохоос сэргийлж ямар бодисыг нэмэх вэ?
- А. Гадаргуугийн идэвхт бодис
 - В. Консервант бодис
 - С. Хүчил
 - Д. Шүлт
 - Е. Өндөр молекулт нэгдэл
- /261./ Зэхмэл бэлтгэхэд жижиглэгдсэн түүхий эдийг тоосонцор хэсгүүдээс ямар хэмжээтэй нүх бүхий шигшүүрээр шигшиж салгах вэ?
- А. 0,2 мм
 - В. 0,5 мм
 - С. 2,0 мм
 - Д. 0,05 мм
 - Е. 1,0 мм
- /262./ Нунтагийн асгарах жин гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?
- А. Чөлөөтэй асгарах нунтагийн нэгж эзлэхүүн дэх жинг хэлнэ
 - В. Нунтаг бодисын хүндийн жинг хэлнэ
 - С. Нунтаг бодисын хувийн жинг хэлнэ
 - Д. Чөлөөтэй асгарах нунтагийн жинг хэлнэ
 - Е. Нунтаг бодисын нягтыг хэлнэ
- /263./ III зэргийн цэвэршилтийн түвшинд технологийн ямар ажилбарыг хийх вэ?
- А. Дрот угаах, тун шил үйлдвэрлэх
 - В. Туслах материал угаах
 - С. Ариутгасан шил савны бөглөөг онгойлгох уусмалыг савлах
 - Д. Уусмал найруулах
 - Е. Уусмал шүүх
- /264./ Дараах тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?

А. Шахмал эм нь нарийн зөв тунлагдсан, тохиромжтой хэмжээний туслах бодис агуулсан, бат бөх, чанар сайтай, тогтоогдсон хугацаанд задарч уусдаг, хатуу эмийн хэлбэр юм.

В. Шахмал нь тодорхой хэмжээний туслах бодис агуулсан, нарийн зөв тунлагдсан, шахах даралтыг маш сайн тохируулсан, даралтын хүчний үйлчлэлд бат бөх чанар 0,05мПа-аас багагүй тогтоогдсон хугацаанд задарч уусдаг хатуу эмийн хэлбэр юм.

С. Шахмал нь стандартад заагдсан үйлчлэгч бодисыг агуулсан, тодорхой хэмжээний туслах бодис агуулсан дээд зэргээр нарийн зөв тунлагдах нөхцлийг хангасан, шахах даралт багатай, бат бөх чанартай тогтоогдсон хугацаанд задарч байх ёстой

Д. Шахмал нь тодорхой хэмжээний туслах бодис агуулсан дээд зэргээр нарийн зөв тунлагдах нөхцлийг хангасан, шахах даралтыг маш сайн тохируулсан, бат бөх чанартай, тогтоогдсон хугацаанд задардаг, үрэлтийн хүчний үйлчлэлд бат бөх чанар нь 95%, шууд шахах аргаар гарган авсан хатуу эмийн хэлбэр юм

Е. Шахмал нь стандартад заагдсан үйлчлэгч бодисыг агуулсан тодорхой хэмжээний туслах бодис агуулсан дээд зэргээр нарийн зөв тунлагдах нөхцлийг хангасан, бат бөх чанартай, тогтоогдсон хугацаанд задардаг чийгтэй мөхлөгжүүлэх аргаар гарган авсан хатуу эмийн хэлбэр юм.

/265./ Гэдсэнд уусдаг бүрхүүлтэй шахмалын задрах хугацааг сонгоно уу?

- A. 30 мин-аас ихгүй
- B. 15 мин-аас ихгүй
- C. 60 мин-аас ихгүй
- D. 5 мин-аас ихгүй
- E. 10 мин-аас ихгүй

/266./ Д зэрэглэлийн өрөөнд дараах ажлуудын алийг нь хийх вэ?

- A. Уусмал найруулах
- B. Туншил угаах
- C. Дрот угаах
- D. Туншил дүүргэх
- E. Хувцас солих

/267./ Аэрозолийн шилэн баллоныг ямар төрлийн шилээр хийдэг вэ?

- A. Саармаг
- B. Хүчиллэг
- C. Шүлтлэг
- D. Кварц
- E. Цахиур

/268./ Ариун эмийн үйлдвэрлэлийн “Д” зэрэглэлд ямар шаардлага тавих вэ?

А. Үсийг боломжтой бол сахлыг ил гаргахгүй битүү далдалсан, хамгаалалтын хувцас тэдгээрт тохирсон гутал өмссөн байх

В. Үсийг боломжтой бол сахлыг ил гаргахгүй битүү далдалсан, өмд цамцны хослол 1 эсвэл 2 ширхэг байх

- C. Толгойн өмсгөл нь үсийг бүрэн далдалсан байх
- D. Өдөр бүр ариутгасан шинэ хувцас өмссөн байх
- E. Усанд орсон байх

/269./ Туншилний бүрэн байдлыг шалгахдаа ямар уусмалд шалгах вэ?

- A. Спиртийн уусмалд
- B. Хлорамины уусмалд
- C. Нэрмэл усанд
- D. Метилен хөхийн уусмалд
- E. Фурациллины уусмалд

/270./ Нунтагийн шахагдах чадвар гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг олно уу?

А. Нунтаг эмийн бодисын бат бөх бүтэцтэй систем үүсгэх чадварыг хэлнэ

В. Нунтаг бодисын нягтрах чадварыг хэлнэ

С. Нунтаг эмийн бодисын бат бөх бүтэцтэй, холбоот дисперсийн систем үүсгэх чадварыг хэлнэ

Д. Нунтаг бодисын янз бүрийн нөхцөлд шахагдах чадварыг хэлнэ

Е. Нунтаг бодисын янз бүрийн бодистой хамт шахагдах чадварыг хэлнэ

- /271./ Амьд эс тодорхой тунтай туяаны энергийг шингээснээр метаболизмын процесс нь алдагддаг ариутгах аргыг нэрлэнэ үү?
- A. Халууны арга
 - B. Шүүж ариутгах арга
 - C. Хэт ягаан туяагаар ариутгах арга
 - D. Радиацийн арга
 - E. Физикийн арга
- /272./ Ариун үйлдвэрлэлийн байрыг агаарын цэвэршилтийн зэргээр хэд ангилдаг вэ?
- A. 2
 - B. 3
 - C. 4
 - D. 5
 - E. 1
- /273./ Бөмбөлөгт тээрэмд жижиглэх гэж буй материалыг бөмбөлөгүүдийн хамт хийхдээ хүрдний эзлэхүүний хэдэн хувьд хийдэг вэ?
- A. 60 %
 - B. 30%
 - C. 50%
 - D. 30-35%
 - E. 40-45%
- /274./ Тарилгын уусмалд ямар онцгой шаардлага тавьдаг вэ?
- A. pH 5,6-6,0
 - B. Халууруулах бодисгүй байх
 - C. Хадгалах хугацаа урт байх
 - D. Хуурай үлдэгдэлгүй байх
 - E. Ангижруулагч бодисгүй байх
- /275./ GMP-ийн шаардлага хангасан үйлдвэрийн байрны хана тааз ямар байх ёстой вэ?
- A. Хана тааз нь гөлгөр ан цавгүй, тэгш өнцөг үүсээгүй байна
 - B. Хана шалтай, хана таазтай холбогдох хэсэг нь тэгш өнцөг үүсгэсэн байна
 - C. Хана тааз нь барзгар гадаргуутай байна
 - D. Шил хана таазыг ногооноор будсан байна
 - E. Шил хана таазыг модоор хийсэн байна
- /276./ Нэрмэл усанд нитрит, нитратын хольц байгаа эсэхийг ямар урвалаар илрүүлэх вэ?
- A. Калийн перманганатын уусмалын өнгийг арилгах
 - B. Хүхрийн хүчлийн орчинд перманганат калийн өнгө арилгах
 - C. Дифениламины уусмалтай хөх өнгө өгнө
 - D. Хүхрийн хүчлийн орчинд перманганат калийн өнгө арилахгүй
 - E. Дифениламины уусмалтай хөх өнгө өгөхгүй.
- /277./ Агаарын босоо ламинар урсгал хэд байдаг вэ?
- A. 0,1 м/сек
 - B. 0,5 м/сек
 - C. 0,45 м/сек
 - D. 0,6 м/сек
 - E. 0,3 м/сек
- /278./ Нунтагийн жижиг хэсгийн хэмжээг тодорхойлох хамгийн энгийн аргыг хэлнэ үү?
- A. Нүдээр харж тодорхойлно
 - B. Гараар тэмтэрч үзэж тодорхойлно
 - C. Шигшүүр хэрэглэж тодорхойлно
 - D. Миллиметрийн хуваарь бүхий шугамаар тодорхойлно
 - E. Машин тоног төхөөрөмжөөр тодорхойлно
- /279./ Бактерцидны лампыг ажил эхлэхээс хэдэн цагийн өмнө ажиллуулах вэ?
- A. 1-2
 - B. 3-4
 - C. 2-4
 - D. 2-3

Е. 4-6

/280./ Дулаанд тэсвэр муутай биологийн идэвхт бодис агуулсан уусмал, ялгамалыг хурдан ууршуулж хатаахад ямар аппарат хамгийн тохиромжтой вэ?

- A. Олон тасалгаат хатаагч
- B. Туузан хатаагч
- C. Тоосруулан хатаагч
- D. Ваакуум булт хатаагч
- E. Хуурамч буцалсан үе үүсгэн хатаагч аппарат

/281./ Мөнгөн усны шар ислийг фурациллин ба рибофлавинаас яаж ялгах вэ

- A. Нэрмэл усанд уусгаж, натрийн шүлт нэмэхэд шар тунадас үүснэ.
- B. Давсны хүчилд уусгаж, натрийн шүлт нэмэхэд шар тунадас үүснэ.
- C. Нэрмэл усанд уусгаж, буцалгахад цагаан тунадас үүснэ.
- D. Хэт ягаан туяанд ногоон флюоресценц үүсгэнэ.
- E. Хүхрийн хүчилд уусгаж, натрийн шүлт нэмэхэд шаравтар тунадас үүснэ.

/282./ Хэрэв тусгайлан заалт байхгүй бол бүрхүүлтэй шахмал эм ямар хугацаанд задрах вэ?

- A. 15 мин-аас ихгүй
- B. 30 мин-аас ихгүй
- C. 5 мин-аас ихгүй
- D. 10 мин-аас ихгүй
- E. 3 мин-аас ихгүй

/283./ Ажлын багаж нь 1 ба хэд хэдэн хутганаас тогтох бөгөөд тэдгээр нь давших ухрах эргэлдэх хөдөлгөөнийг хийдэг. Энэ ямар машин бэ?

- A. Өвс хэрчигч
- B. Үндэс хэрчигч
- C. Дизмембратор
- D. Хоолойт тээрэм
- E. Бөмбөлөгт тээрэм

/284./ Бүх материал бүтээгдэхүүнийг хадгалахдаа хамгийн түрүүнд дотогш оруулах, хамгийн түрүүнд гадагш гаргах салаавчилсан дүрмийг баримталж байршуулна. Учир нь үйлдлийн дэс дараалалыг зөв баримтлахад зохистой байдаг.

/285./ Жижиглэх процессын дүнд хатуу биетийн гадаргуугийн талбай ихэсдэг. Тийм учраас бодисыг жижиглэх процессын онолын үндэс нь зөвхөн гадаргуугаар жижиглэгддэг гэж үздэг.

/286./ Шахмал хийх массанд холбогч бодисыг их хэмжээгээр нэмж өгөх шаардлагтай. Учир нь холбогч бодисын тусламжтайгаар шахмал эмийн хэлбэрээс эмийн бодис хурдан чөлөөлөгдөж эмчилгээний үйлдлийг сайжруулдаг.

/287./ Хатуу желатинан капсулыг гарган авахдаа дүүрэн аргыг хэрэглэдэг. Энэ арга нь тогтмол темпертуртай желатины уусмалд тэнхлэгээрээ эргэлдэх олон тооны металл хэвийг дүрээд авахдаа капсул хэлбэр үүсгэхэд үндэслэгддэг.

/288./ Шахмал эмийн чийгтэй мөхлөгжүүлэх аргаар гарган авахдаа хөвсийлгөгч бодисын уусмалыг ашигладаг. Учир нь бат бөх чанартай холбоот дисперсийн систем үүсгэхийн тулд цавууг ашигладаг.

/289./ Зарим тарилгын уусмалыг ариутгах үед температурын нөлөөгөөр хими-физикийн өөрчлөлтөд ордог. Ийм учраас түүнийг тогтворжуулах зорилгоор антиоксидант бодис нэмдэг.

/290./ Аэрозоль эмийн хэлбэрийг тээвэрлэх, хадгалахад онцгой нөхцөл шаарддаг. Учир нь цохилтын хүч, нарны туяаны шууд нөлөө, температурын огцом өсөлт зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр эмийн бодисын үйлдэл буурдаг.

/291./ Бөмбөлөгт тээрмийн эргэлдэх хурд хэт бага байвал бөмбөлгүүд өндөрт өргөгдөж чаддаггүй. Ийм учраас жижиглэлт үр дүн муутай явагддаг.

/292./ Нэгэн жигд ширхэгтэй элсэн чихрийн ширхэгээр үрлийн цөмийг бэлтгэдэг. Учир нь жигд бус ширхэгтэй сахах авбал үрлийн цөм бэлтгэх явцад хэлбэр, дүрс, хэмжээ нь өөрчлөгдөж үрлийн чанарт муугаар нөлөөлдөг.

/293./ Тарилгын эмийн хэлбэрийг бэлтгэхэд хүйтэн аргаар гарган авсан ургамалын шингэн тосыг хэрэглэдэг. Учир нь хүчлийн тоо их байвал мэдрэлийн төгсгөлийг цочроож тарихад өвдөлт үүсгэж болно .

/294./ Саармагжуулах аргын ацидиметрийн аргаар тооны тодорхойлолт явуулах эмийн бодисуудыг олж нэрлэ.

1. Натрийн салицилат
2. Натрийн бензоат
3. Фенилсалицилат
4. Бензойны хүчил
5. Салицилийн хүчил

/295./ Фармакопейн заалтаар эмийн бэлдмэлүүдээс алиныг нь танихад төмрийн хлорид (III) –ыг урвалж болгон хэрэглэхээр заасан вэ?

1. Бромидууд
2. Ацетатууд
3. Иодидууд
4. Бензоатууд
5. Фосфатууд

/296./ Гликозид бүтэцтэй антибиотуудыг нэрлэнэ үү?

1. Стрептомицин
2. Неомицин
3. Гентамицин
4. Мономицин
5. Цефазолин

/297./ Шахмал эмийн хэлбэрээр үйлдвэрлэдэг эмүүдийг нэрлэ.

1. Гексамидин
2. Бензонал
3. Фенобарбитал
4. Тиопентал
5. Гексинал

/298./ Йодын ямар бэлдмэлийг анагаах ухааны практикт хэрэглэдэг вэ?

1. 5%-ийн спиртэн уусмал
2. 10%-ийн спиртийн
3. Люголийн уусмал
4. 5%-ийн усан уусмал
5. 10%-ийн тосон уусмал

/299./ Этилийн спиртийн градусыг хэмжих багаж аль нь вэ?

1. Термометр
2. Спиртомер
3. Рефрактометр
4. Денсиметр
5. Поляриметр

/300./ Дараах эмүүдээс алийг нь шахмал хэлбэрээр хэрэглэгддэг эмийг нь заана уу.

1. Тетрациклин
2. Парацетамол
3. Феноксиметилпенициллин
4. Сульфанидамид
5. Аскорбины хүчил

/301./ Комплексонометрийн аргад ямар индикаторуудыг хэрэглэх вэ?

1. Эрихром хар
2. Хүчиллэг хром хар хөх
3. Мурексид
4. Фенолфталеин
5. Метил улаан

/302./ Фармакопейн дагуу 1 гр эмийн бодисыг өгөгдсөн 100 мл хүртэл уусгагчид хийж 18-220С температурт сэгсрэхэд 10 минутанд ууссан бол уусалт нь ямар бодис вэ?

1. Маш хялбар
2. Хялбар
3. Муу уусдаг
4. Аажим уусдаг
5. Маш муу уусдаг

/303./ Морфины гидрохлоридын тооны тодорхойлолтыг ямар аргуудаар хийдэг вэ?

1. Аргентометрийн
2. Усан биш орчинд ацидиметрийн
3. Меркуриметрийн
4. Иодометрийн
5. Нитритометрийн

/304./ Глюкозын тооны тодорхойлолтонд ямар аргуудыг хэрэглэх вэ?

1. Йодомер
2. Фотометр
3. Рефрактометр
4. Къелдаль
5. Аргентометр

/305./ Фармакопейн дагуу 1 гр эмийн бодисыг өгөгдсөн 20 мл хүртэл уусгагчид хийж 18-220С температурт сэгсрэхэд 10 минутанд ууссан бол уусалт нь ямар бодис вэ?

1. Маш хялбар
2. Хялбар
3. Аажим уусдаг
4. Уусдаг
5. Маш муу уусдаг.

/306./ Цефалоспорины антибиотик эмүүдийг нэрлэнэ үү?

1. Цефазолин
2. Цефалоризин
3. Клафоран
4. Фортум
5. Клоксациллин

/307./ Саармагжуулах аргаар тодорхойлоход хэрэглэх индикаторуудыг сонго

1. Кали хромат
2. Метил улаан
3. Цардуул
4. Феналфталеин
5. Хүчиллэг хром хар хөх

/308./ Дараах эмүүдээс аль нь усанд уусдаггүйг нэрлэнэ үү?

1. Адреналины гидрохлорид
2. Скопаламины гидробромид
3. Гоматропины гидробромид
4. Барийн сульфат
5. Морфины гидрохлорид

/309./ Новокайн дээр ямар урвалж хийхэд тосорхог тунадас үүсэх вэ?

1. NaCl
2. Cu(OH)₂
3. MgCO₃
4. NaOH 20%

5. Na_2CO_3

/310./ Шүлтийг тодорхойлоход ажлын уусмалаар юуг сонгон хэрэглэх вэ?

1. Натрийн гидроксид
2. Давсны хүчил
3. Калийн гидроксид
4. Хүхрийн хүчил
5. Иодын уусмал

/311./ Эмийн бэлдмэлийг халуун орчинд хадгалахад ямар өөрчлөлт явагдах вэ?

1. Хайлах
2. Уурших
3. Талст усаа алдах
4. Исэлдэх
5. Задрах

/312./ Үнэрт ацетаминь эмийн бэлдмэлүүдэд доорх эмийн бэлдмэлүүдээс аль нь орох вэ?

1. Ацетилсалицилийн хүчил
2. Парацетамол
3. Салицилийн хүчил
4. Фенацетин
5. Салицилат натри

/313./ Дараах эмийн уусмалуудаас тарилгаар хэрэглэдэг уусмалуудыг заана уу?

1. MgSO_4
2. CaCl_2
3. NaCl
4. $\text{Na}_2\text{B}_4\text{O}_7$
5. NaBr

/314./ Бамбай булчирхайн гормонуудаас нийлэг эмийг нэрлэнэ үү?

1. Тиреоидин
2. Дийодтирозин
3. Инсулин
4. Бетазин
5. Тироксин

/315./ Фармакопейн дагуу 1 гр эмийн бодисыг өгөгдсөн 1 л хүртэл уусгагчид хийж 18-220С температурт сэгсрэхэд 10 минутанд ууссан бол уусалт нь ямар бодис вэ?

1. Маш хялбар
2. Хялбар
3. Аажим уусдаг
4. Муу уусдаг
5. Маш муу уусдаг.

/316./ Дараах нэгдлүүдээс аль нь усанд хялбар уусах вэ?

1. Аминазин
2. Тиаминь бромид
3. Рибофлавин
4. Аскорбины хүчил
5. Ретинол

/317./ Саармагжуулах аргын алкалиметрийн аргаар тооны тодорхойлолт явуулах эмийн бодисуудыг олж нэрлэ.

1. Натрийн бензоат
2. Бензойны хүчил
3. Натрийн салицилат
4. Салицилийн хүчил
5. Фенилсалицилат

/318./ Нитритометрийн аргад ямар индикаторуудыг хэрэглэдэг вэ?

1. Фенолфталеин
2. Тропеолин ОО
3. Метилийн улаан

4. Йод цардуулын цаас

5. Метилийн хөх

/319./ Урвуу титрлэлт гэж юу вэ?

1. Тодорхойлох бодистой ажлын уусмалыг шууд хийх.

2. Тодорхойлох бодисыг ямар нэгэн урвалж бодистой урвалд оруулж бүтээгдэхүүнийг ажлын уусмалаар титрлэх

3. Тодорхойлох бодисыг ямар нэгэн урвалж бодистой урвалд оруулж илүүдлийг титрлэнэ.

4. Тодорхойлох бодис руу мэдэгдэж буй концентрацитай уусмалыг илүүдлээр нэмж үлдэгдэлийг нь ажлын уусмалаар титрлэнэ.

5. Тодорхойлох бодис руу ямар нэгэн концентрацитай уусмалыг илүүдлээр нэмж үлдэгдэлийг нь ажлын уусмалаар титрлэнэ.

/320./ Тиамины бромидыг ямар эмтэй нэг зэрэг тарьж хэрэглэж болдоггүй вэ?

1. Аскорбины хүчил

2. Пиридоксины гидрохлорид

3. Пенициллин, стрептомицин

4. Цианокобаламин

5. Витамин РР

/321./ Дараах гормонуудаас эм бэлгийн гормонуудыг нэрлэ.

1. Этинилстрадиол

2. Эстрадиолын дипропинат

3. Синэстрол

4. Тестостерон

5. Метилтестостерон

/322./ Дараах эмийн бодисуудаас алиныг нь буруу хадгалахад дэлбэрэх аюултай нэгдэл үүсдэг вэ?

1. Этилийн спирт

2. Фторотан

3. Диэтилийн спирт

4. Нитроглицерин

5. Хлоралгидрат

/323./ Хүчлийг тодорхойлоход ажлын уусмалаар юуг сонгон хэрэглэх вэ?

1. Давсны хүчил

2. Натрийн гидроксид

3. Хүхрийн хүчил

4. Калийн гидроксид

5. Калийн перманганат

/324./ Цефалоспорины антибиотик эмүүдийг нэрлэнэ үү?

1. Цефазолин

2. Цефалоризин

3. Клафоран

4. Фортум

5. Клоксациллин

/325./ Комплексонометрийн аргаар дараах бэлдмэлүүдийн алийг нь тодорхойлох вэ?

1. Цинк сульфат

2. Магнийн сульфат

3. Кальцийн лактат

4. Натрийн цитрат тарилгад зориулсан

5. Кальцийн хлорид

/326./ Нитритометрийн аргад ямар индикаторуудыг хэрэглэдэг вэ?

1. Фенолфталеин

2. Тропеолин

3. Метилийн улаан

4. Йод цардуулын цаас

5. Метилен хөх

/327./ Цардуулын уусмалыг титрлэлтийн аль үед нь нэмэх вэ?

1. Титрлэлтийн өмнө хийнэ
2. Титрлэлтийн дунд хийнэ
3. Титрлэлтийн эхэнд хийнэ
4. Титрлэлтийн төгсгөл хавьд хийнэ
5. Титрлэлтийн эхэн ба дунд үед

/328./ Тооны тодорхойлолтонд йодометрийн аргыг хэрэглэж болох бодисыг заана уу?

1. Витамин РР
2. Витамин С
3. Витамин А
4. Нитрофурантоин
5. Витамин Е

/329./ Нэг дусал уусмал уруу аммоны оксалат хийхэд оксалатын цагаан тунадас үүснэ. Энэ цагаан тунадас эрдсийн хүчилд уусна. Энэ ямар бэлдмэлийг таних урвал вэ?

1. Хөнгөн цагааны ислийн гидрат
2. Кальци хлорид
3. Магни сульфат
4. Кальци глюконат
5. Хөнгөн цагааны хлорид

/330./ Витамин В6 –ийн чанарын шинжилгээнд ямар урвалыг ашиглах вэ?

1. 2,6 дихлорбензолтой явагдах
2. FeCl₃-тай урвал
3. Азобудаг үүсгэх
4. Аммикийн буфер, 2,6 дихлорхинонхлоримид ба бутанолтай явагдах
5. Метилжих

/331./ Дараах гормонуудаас анаболик эмүүдийг нэрлэнэ үү

1. Метандростенолон
2. Метиландростендиол
3. Анаболин
4. Нероболит
5. Диэтилстильбэстрол

/332./ Дараах эмүүдээс FeCl₃-тай урвалд ордог нь аль вэ?

1. FeCl₃
2. Аскорбины хүчил
3. NaCl
4. Формальдегид
5. NaBr

/333./ Эргокальциферолыг гэрлээс болон агаарын хүчилтөрөгч орохоос хамгаалан хадгалдагийн учир нь юу вэ?

1. Гэрлийн нөлөөгөөр холекальциферол үүснэ.
2. Агаарын хүчилтөрөгч нь витамин D исэлдүүлнэ
3. Агаарын хүчилтөрөгч нь витамин D ангижруулна.
4. Гэрлийн нөлөөгөөр хортой токсистерин үүснэ.
5. Өөрчлөгдөхгүй.

/334./ Альдегидын эмийн бэлдмэлүүдийг ол

1. Формальдегид
2. Хлоралгидрат
3. Гексаметилентетрамин
4. Демидрол
5. Кальциглюконат

/335./ Йодын спиртэн уусмал дахь йодыг таньж тодорхойлоход дараах урвалуудын алиныг нь ашиглах вэ?

1. Цардуулын уусмалтай хөх өнгө үүснэ.
2. Хлороформтой сэгсрэхэд ягаан өнгө үүснэ.
3. Натрийн тиосульфаттай холиход өнгөгүй болох
4. Хлороформтой сэгсрэхэд бор шар өнгө үүсэх

5. Мөнгөний нитраттай хар тунадас үүсгэхгүй
- /336./ Эуфиллины бүтэц найрлага аль нь вэ?
1. Теофиллин + бензоат натри
 2. Кофейн+этилендиамин
 3. Теобромин+этилендиамин
 4. Теофиллин + этилендиамин
 5. Теобромин+бензоат натри
- /337./ Гексаметилентетрамины тооны тодорхойлолтыг ямар аргуудаар хийх вэ?
1. Алкалиметрийн арга
 2. Ацидиметрийн арга
 3. Иодометрийн арга
 4. Комплексонометрийн арга
 5. Аргентометрийн арга
- /338./ Үндэсний болон олон улсын фармакопейн заалтууд ямар шинжийг агуулах вэ?
1. Үндэсний болон олон улсын фармакопейн заалтыг заавал мөрдөнө.
 2. Үндэсний фармакопейн заалтыг тухайн оронд заавал мөрдөнө.
 3. Олон улсын ба үндэсний фармакопейн заалт нь зөвлөх шинж чанартай.
 4. Олон улсын фармакопейн заалт нь зөвлөх шинж чанартай.
 5. Олон улсын фармакопейн бүх оронд заавал мөрдөнө.
- /339./ Дараах гормонуудаас эр бэлгийн гормонуудыг нэрлэ.
1. Прогестерон
 2. Тестостерон
 3. Прегнин
 4. Метилтестостерон
 5. Синэстрол
- /340./ Өнчин тархины гормонуудыг нэрлэнэ үү?
1. Питунтрин
 2. Вазопрессин
 3. Окситоцин
 4. Инсулин
 5. Адреналин
- /341./ Цахилгаан соронзон цацралын шингээлтийг хэмжихэд үндэслэсэн аргуудыг заана уу?
1. ХЯТ-ы спектрофотометр
 2. НУТ-ы спектроскопи
 3. Фотоколориметри
 4. Рефрактометри
 5. Поляриметри
- /342./ Иодын спиртэн уусмал дахь йодыг таниж тодорхойлоход дараах урвалуудын алиныг нь ашиглах вэ?
1. Цардуулын уусмалтай хөх өнгө өгөх
 2. Хлороформтой сэгсэрэхэд ягаан өнгө өгөх
 3. Натрийн тиосульфаттай холиход өнгөгүй болох
 4. Хлороформтой сэгсэрэхэд бор шар өнгө үүсгэх
 5. Мөнгөний нитраттай хар тунадас үүсэхгүй
- /343./ Титрийн уусмалыг яаж бэлтгэх вэ?
1. Концентрацитай уусмалаас
 2. Химийн цэвэр бодисоос фармакопейн дагуу
 3. Сулруулсан уусмалаас
 4. Фиксаналаас
 5. Уусмалаас
- /344./ CaCl_2 –нь юунд уусдаг вэ?
1. Спиртэнд уусна.
 2. Усанд уусна
 3. Ус, спиртэнд уусна.
 4. Хлорформд уусна

5. Ус, спиртэнд уусахгүй

/345./ Титриметрийн шинжилгээнд заавал мөрдөх шаардлагуудыг сонго.

1. Харилцан үйлчлэлцэж буй уусмалуудын эзэлхүүн тодорхой нарийн байх
2. Концентраци нь урьдчилан мэдэгдэж буй ажлын уусмал хэрэглэх.
3. Урвалын төгсгөлийг тодорхойлох.
4. Урвалын эхлэлийг тодорхойлох
5. Концентраци нь тодорхойгүй ажлын уусмал хэрэглэх

/346./ Глюкозын тооны тодорхойлолтонд ямар аргуудыг хэрэглэх вэ?

1. Йодометр
2. Фотометр
3. Рефрактометр
4. Къелдаль
5. Аргентометр

/347./ Сулруулсан давсны хүчлийн уусмалыг дараах заалтын алинд нь хэрэглэдэггүй вэ?

1. Ходоодны хүчил багадсан үед
2. Цус багадалтанд төмрийн бэлдмэлийг хэрэглэх үед
3. Хоолны шингэц муудсан үед пепсинтэй холимог шингэнээр
4. Ходоодны хүчил ихэдсэн үед
5. Төмрийн бэлдмэл хэрэглэх үед

/348./ Калийн болон натрийн хлоридуудыг ямар аргуудаар тооны тодорхойлолт хийх вэ?

1. Аргентометрийн Гейлюсак
2. Аргентометрийн Морийн арга
3. Аргентометрийн Фаянсийн арга /натрийн эозинат/
4. Аргентометрийн Фольгард
5. Аргентометрийн Фаянс /бромфенол хөх/

/349./ Анхдагч үнэрт амин бүлэг агуулсан эмүүдийг ямар урвалаар таних вэ?

1. Мурексидийн сорил
2. Лигнины сорил
3. Витали-Морены сорил
4. Азобудаг
5. Бальегийн сорил

/350./ Фталазолыг юутай урвалд оруулахад флюоресценци ногоон өнгө үүсгэх вэ?

1. Резорцин+натрийн шүлт
2. Резорцин +давсны хүчил
3. Конц хүхрийн хүчил+натрийн шүлт
4. Конц хүхрийн хүчил+резорцин+натрийн шүлт
5. Конц давсны хүчил+натрийн шүлт

/351./ Усанд аль эм хялбар уусдаг вэ?

1. Фенилсалицилат
2. Ацетилсалицилийн хүчил
3. Тимол
4. Новокайн
5. Резорцин

/352./ Аскорбины хүчлийн уусмалыг тогтворжуулахын тулд натрийн метагидросульфат эсвэл натрийн сульфат тулд нэмж өгнө. Учир нь аскорбины хүчил агаар металл, хүчил шүлтийн нөлөөгөөр амархан исэлддэг.

/353./ Тропаны уламжлалын алкалоидууд Витали-Морены сорил өгдөг. Учир нь нийлмэл эфир задарч хүхрийн хүчил үүсснээс энэ урвалыг өгнө.

/354./ Формальдегидыг исэлдүүлэх урвалд оруулахад хар тунадас үүсэв. Учир нь урвалын дүнд Ag ялгарна.

/355./ +5°C-д формальдегидыг хадгалахад цагаан тунадас бууна. Учир нь формальдегид исэлдэх урвалд орно.

/356./ Аскорбины хүчлийн уусмалыг тогтворжуулахын тулд натрийн метагидросульфат эсвэл натрийн сульфит нэмж өгнө. Учир нь аскорбины хүчил агаар металл, хүчил шүлтийн нөлөөгөөр амархан ангижирдаг.

/357./ Тропаны бүлгийн алкалоидын чанарын шинжилгээнд Витали-Морены сорилыг хэрэглэдэг. Энэ нь алкалоидыг гидролизд оруулсны дараа нитрожуулж, ацетоны орчинд калийн гидроксидоор үйлчлэхэд хиноид бүтэц үүсэх шинж чанарт үндэслэгдэнэ.

/358./ Тропаны уламжлалын алкалоидууд Витали-Морены сорил өгдөг. Учир нь нийлмэл эфир задарч тропин үүсснээс энэ урвалыг өгнө.

/359./ Тропаны уламжлалын алкалоидууд Витали-Морены сорил өгдөг. Учир нь нийлмэл эфир задарч спирт үүсснээс энэ урвалыг өгнө.

/360./ Формальдегидыг исэлдүүлэх урвалд оруулахад улаан тунадас үүсэв. Учир нь исэлдүүлэх урвалын дүнд Ag үүснэ.

/361./ Морын арга гэдэг нь мөнгөний ион, хлорын ионы хооронд явагдах урвал дээр үндэслэгдсэн арга . Учир нь титрийн уусмал нь 0,1N мөнгөний нитрат.

/362./ Тропаны бүлгийн алкалоидын чанарын шинжилгээнд Витали-Морены сорилыг хэрэглэдэг. Энэ нь алкалоидыг гидролизд оруулсны дараа нитрожуулж, ацетоны орчинд калийн гидроксидоор үйлчилж, саванжих шинж чанарт үндэслэгдэнэ.

/363./ Тропаны бүлгийн алкалоидын чанарын шинжилгээнд Витали-Морены сорилыг хэрэглэдэг. Энэ нь алкалоидыг гидролизд оруулсны дараа нитрожуулж, хиноид бүтэц үүсгэх шинж чанарт үндэслэгдэнэ.

/364./ Формальдегидыг исэлдүүлэх урвалд оруулахад улаан тунадас үүсэв. Учир нь исэлдүүлэх урвалын дүнд Cu_2O үүснэ.

/365./ Фенолт нэгдлүүдийн төмрийн хлоридтой урвалд ороход илрэх өнгө өөр өөр байдаг. Учир нь энэ нь тухай нэгдлийн найрлаганд орох бусад функциональ бүлгүүдээс хамаарна.

/366./ Тропаны уламжлалын алкалоидууд Витали-Морены сорил өгдөг. Учир нь нийлмэл эфир задарч тропын хүчил үүсснээс энэ урвалыг өгнө.

/367./ Asteracea нь юуны овог вэ?

- A. Сэрдэгтэн
- B. Гол өвстөн
- C. Үетэн
- D. Нийлмэл цэцэгтэн
- E.

Тарна

/368./ Хуруувчин цэцгийн гол үйлчлэгч бодис

- A. Алкалоид
- B. Аргаах бодис
- C. Зүрхний гликозид
- D. Флавоноид
- E. Эфирийн тос

/369./ Сибирийн зүрхэн цэцэг ямар овгийн ургамал вэ?

- A. Polygalaceae
- B. Fabaceae
- C. Equisetaceae
- D. Rosaceae
- E. Malvaceae

/370./ Кузьмичийн өвс гэж ямар ургамал вэ?

- A. Хүн хорс
- B. Лидэрийн өвс
- C. Тарваган шийр
- D. Ээрим шарилж
- E. Шивлээхэй зээргэнэ

/371./ Үхэр мэхээрийн химийн бүрэлдэхүүн.

- A. ЭФирийн тос
- B. Флаванойд
- C. Аргаах бодис
- D. Салс
- E. Аскорбины хүчил

/372./ Усан тарны эмчилгээний үйлдлийг сонго.

- A. Даралт бууруулах
- B. Умайн булчинг агшаах, цустогтоох
- C. Цөс ба шээс хөөх
- D. Элэгний үрэвсэл
- E. Тайвшруулах

/373./ Усанд уусдаг витаминг нэрлэ

- A. A,D,E,K
- B. C, P,PP, B
- C. PP, B, A,D,
- D. C, P, E,K
- E. P,PP, A,B

/374./ Шарилжны ханд, Инсулин, Амитриптилин зэрэг эм хэрэглэхэд ямар шинж илрэх вэ?

- A. Хоолны дуршил буурах
- B. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн ихсэх
- C. Ходоодны шүүрэл ялгаралт буурах
- D. Цөс хөөх
- E. Хоолны дуршил ихсэх

/375./ Ханасан өөхний хүчлүүд нь ямар шинж чанартай вэ?

- A. Хагас шингэн
- B. Өтгөн
- C. Шингэн
- D. Хатуу
- E. Зуурамтгай

/376./ Гидрогенжих гэж юу вэ?

- A. 100гр өөх тосонд агуулагдах иодын тоохэмжээг хэлнэ
- B. Өөх тос шүлтийн нөлөөгөөр гидролизод орж глицерин ба өөхний хүчил задрахыг хэлнэ
- C. Өөх тосны найрлаганд ууссан янз бүрийн физик химийн бодисууд их бага ямар нэг хэмжээгээр дагалдах байдлыг хэлнэ
- D. 1 гр нийлмэл эфирийн задралаар үүсч буй хүчлийг хэлнэ
- E. Шингэн тосны гүйцэт өөхний хүчлийн хоёрчийн холбоонд устөрөгч нэгдэх үзэгдлийг хэлнэ

/377./ Эгэл маалинга ямар овгийн ургамал вэ?

- A. Linaceae
- B. Malvaceae
- C. Rosaceae
- D. Solanaceae
- E. Fabaceae

/378./ Эмийн багваахайн эмчилгээний үйлдлийг сонго.

- A. Даралт бууруулах
- B. Цус тогтоох
- C. Шээс хөөх
- D. Үрэвслийн эсрэг
- E. Хоол боловсруулах эрхтний үйл ажиллагааны хямрал

/379./ Тарваган шийр юуны овог вэ?

- A. Rosaceae
- B. Asteraceae
- C. Polygonaceae
- D. Fabaceae
- E. Poaceae

/380./ Эм зүйн практикт ямар аргаар шахсан тосыг хэрэглэдэг вэ?

- A. Халууны аргаар
- B. Хүйтний аргаар
- C. Органик уусгагчаар хандалсан
- D. Физик аргаар гарган авсан
- E. Химийн аргаар гарган авсан

/381./ Эмийн бодис гэж юу вэ?

A. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэдэг химийн өвөрмөц нэгдэл юм.

B. Эмчилгээний буюу урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай үр нөлөө гаргахын тулд эмийн зүйлийг хэрэглэхэд тохиромжтой хэлбэрт оруулсаныг хэлнэ.

